МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР САНГИЙН ЯАМ

**БАТЛАВ: Захиалагчийг төлөөлж:**

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА: Ч.ЧИМИДСҮРЭН

**БАТЛАВ: Гүйцэтгэгчийг төлөөлж:**

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ц.БОЛОРМАА

# ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ СЯ 1605 ТООТ ГЭРЭЭНИЙ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2020 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

## 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

| Гэрээний нэр | Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх |
|---|---|
| Гэрээний дугаар | СЯ 1605 |
| Захиалагч байгууллага | Сангийн яам |
| Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар |
| Гүйцэтгэгч байгууллага | Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг |
| Гэрээгээр ажил эхлүүлсэн хугацаа | 2020 оны 1-р сарын 1 |
| Гэрээт ажлыг дүгнэсэн хугацаа | 2020 оны 7-р сарын 1 |

## 2. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

| Гэрээний үүргийн нөхцөл | Хэрэгжилт | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|
| 3.1.1<br>ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг тус тус батлуулан мөрдүүлж, шалгалтыг зохион байгуулах; | */ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №1/*<br>✓ Татварын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан ТМЗН-ээс зохион байгуулагддаг үндсэн сургалтын гарын авлагад хууль эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтийг тусган хэвлүүлж, Зохиогчийн эрхийн тухай хуулийн хүрээнд Оюуны өмчийн газраар баталгаажуулж сургалтад ашиглаж байна. | 100% |
| | *Татварын мэргэшсэн зөвлөх /ТМЗ/ - ийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр:*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №2/*<br>✓ ТМЗҮтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах журмын 2 | 70% |

| | | |
|---|---|---|
| | дугаар зүйлийн 2.12 дахь заалт болон сургалтын үр дүн, нөөц бололцоо, олон улсын зарим туршлагад үндэслэн Монгол Улсын ТМЗН-ийн сургалтын өнөөгийн нөхцөл, ирээдүйн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглүүлэн ТМЗ-ийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2020 оны 4 дүгээр сарын 30-ны 02/51 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.<br>*<u>ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх, сунгах сургалт:</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №3/*<br>ТМЗН нь бүх сургалтуудаа цахимд шилжүүлэх ажлыг богино хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн.<br>✓ ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтын бүх хичээлийг 100 хувь цахимд шилжүүлэн, нийт 2059 минутын хичээл бүхий цахим сургалтыг зохион байгуулан 236 хүн хамруулллаа.<br>ТМЗ-ийн эрх сунгах цахим сургалтын ШИНЭЧЛЭЛ-ийг зохион байгуулж хэрэгжүүллээ. Үүнд:<br>✓ ТМЗ-ийн эрхийг анх удаа сунгах цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 48 гишүүн;<br>✓ ТМЗ-ийн эрхийг дахин сунгах цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 158 гишүүн тус тус хамрагдлаа. | 100% |
| | *<u>Цахим сургалт зохион байгуулах:</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №4/*<br>✓ ТМЗ-үүдэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломж олгох зорилгоор тасралтгүй боловсролын цахим сургалтын сэдэв, төрлийг нэмэгдүүлж 6 хичээлийг шинээр бэлтгэн цахимд байршуулллаа.<br>✓ Сорил шалгалтад бэлтгэх сургалтыг цахимд бүрэн шилжүүллээ. Татварын англи хэл, Санхүү болон өртөг удирдлагын бүртгэл хичээлээр явагддаг уг сургалтыг цахимаар 3 удаа зохион байгуулж 24 нягтлан бодогч хамрагдсан байна. | 100% |
| | *<u>ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын бүрэлдэхүүнийг томилж, батлуулах:</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №5/*<br>✓ Монгол Улсын Сангийн сайд 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн №80 тоот тушаалаар Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг баталсан. | 100% |
| | *<u>ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах:</u>*<br>*ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №6/*<br>*<u>ТМЗ-д эрх олгох шалгалтыг:</u>*<br>➢ Улаанбаатар хотод 2020 оны 6 сарын 17-19-ний | 100% |

| | | |
|---|---|---|
| | өдрүүдэд;<br>➢ Ховд аймаг<br>➢ Увс<br>➢ Баянхонгор<br>➢ Хөвсгөл<br>➢ Орхон<br>аймгуудад тус тус зохион байгуулж 392 хүн хамрагдсанаас 51 хүн тэнцсэн байна.<br>*<u>ТМЗ-ийн эрх сунгах шалгалтыг</u>*<br>хуваарийн дагуу цахимаар зохион байгуулж:<br>➢ ТМЗ-ийн эрх анх сунгах шалгалтад нийт 52 гишүүн хамрагдахаас 48 хамрагдаж<br>➢ ТМЗ-ийн эрх дахин сунгах шалгалтад нийт 174 гишүүн хамрагдахаас 158 хамрагдсан. | |
| 3.1.2<br>ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх; татварын мэргэшсэн зовлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангаж, тэдгээрийн бүртгэл. мэдээллийн санг бүрдүүлэх | *<u>ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хэрэглэгдэх ерөнхий аргачлалын журмын төслийг боловсруулах;</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №7/*<br>✓ Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний ерөнхий стандартын шинэчлэлийг Удирдах зөвлөлийн 2019 оны 12 сарын 16-ны өдрийн хурлаар баталсан болно. Уг стандартад “Стандартыг хэрэгжүүлэх аргачлал”-ыг нэмж оруулан батлуулсан.<br>*<u>ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд хяналт шалгалт хийх;</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №8/*<br>✓ СЯ-тай хамтран Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн, Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №93 тоот тушаалаар ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд хяналт шалгалт хийгдэж байна. Энэ удаагийн хяналт шалгалтад нийт 21 хуулийн этгээд хамрагдаж байна.<br><br>*<u>СЯ-тай хамтран ТМЗҮ эрхэлж буй хуулийн этгээдийн цахим мэдээллийн санг шинэчлэх;</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №9*<br>✓ ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн цахим мэдээллийн санг СЯ-ны НБББГ болон ТМЗН үүсгэн ажиллаж байгаа бөгөөд ТМЗ компаниудын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдах бүрт тухайн хуулийн этгээдийн мэдээллийн шинэчлэл хийгдэж байгаа болно.<br>*<u>СЯ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд семинар, сургалт зохион</u>* | 90%<br><br><br><br>90%<br><br><br><br>100% |

| | | |
|---|---|---|
| | *байгуулах;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №10*<br>✓ Тасралтгүй боловсролын сургалтыг тогтмол зохион байгуулж, 4 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэлх хугацаанд “Мэргэжлийн үнэ цэнэ, ТМЗ-ийн ёс зүй”, “Татварын ерөнхий хууль, шинэчилсэн найруулга” сэдэвт хөгжүүлэх сургалтуудыг үнэ төлбөргүйгээр, цахимаар зохион байгуулж ТМЗ гишүүдийнхээ мэдлэг боловсролыг дэмжин ажилласан.<br>✓ Хамтдаа хөгжье цахим сургалтыг Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд нийт санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдэд цувралаар үнэ төлбөргүй зохион байгууллаа. | 100% |
| | *ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй эрхэлж буй хуулийн этгээдүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах тухай санал СЯ-нд хүргүүлэх;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №11/*<br>✓ ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй хэрэгжүүлсэн тохиолдолд зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх тухай цахим мэдэгдлийн загварыг боловсруулж 2019 оны 11 сарын 20-ны өдрийн 02/98 албан тоотоор СЯ-ны НБББГ-т хүргүүлсэн болно. | 80% |
| | *ТМЗҮ тусгай зөвшөөрөл нь Хүчингүй болсон хуулийн этгээдүүдийн нэрнээс “ТМЗ” үгийг хасах ажлыг зохион байгуулах.*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №12/*<br>✓ Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон эсвэл зөрчил гаргаж, сануулгын хугацаанд зөрчилөө арилгаагүй хуулийн этгээдүүд Сангийн сайдын тушаалаар хүчингүйд тооцогдсон. Тэдгээр хуулийн этгээдүүдийн нэрнээс ТМЗ гэсэн үгийг хасуулахаар УБЕГ-т албан тоот хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.1.3<br>Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг Захиалагчид тавьж шийдвэрлүүлэх | *ТМЗҮ тусгай зөвшөөрөл нь Хүчингүй болсон хуулийн этгээдүүдийн нэрнээс “ТМЗ” үгийг хасах ажлыг зохион байгуулах.*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №13/*<br>✓ Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон эсвэл зөрчил гаргаж, сануулгын хугацаанд зөрчлөө арилгаагүй хуулийн этгээдүүд Сангийн сайдын тушаалаар хүчингүйд тооцогдсон. Тэдгээр хуулийн этгээдүүдийн нэрнээс ТМЗ гэсэн үгийг хасуулахаар УБЕГ-т албан тоот хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | |
|---|---|---|
| 3.1.4<br>Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоож мөрдүүлэх | Өөрчлөлт ороогүй. | |
| 3.1.5<br>Шалгалтын тестийн сан бүрдүүлэх. татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх; | *ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын тестийн санг цахимжуулах, шалгалт зохион байгуулагдах бүрд хичээл тус бүрээр нэмэгдүүлэх;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №14/*<br>✓ ТМЗ-ийн эрх сунгах шалгалт (анх болон дахин), ТМЗ-д эрх олгох шалгалтын Хууль эрх зүй, татварын бүртгэл хичээлийн шалгалтын тестийн санг хуулийн шинэчлэлтэй уялдуулан бүрэн шинэчилж, хичээл тус бүрээр 50-70 тест;<br>✓ НББОУСХ хичээл -50 асуулт, 5 бодлого;<br>✓ Татварын онол – 50 асуултаар тестийн санг тус тус нэмэгдүүлж, шинэчлэх ажил тасралтгүй хийгдсээр байна. | 100% |
| | *Нягтлан бодогч мэргэжлээр /бакалавр, магистр, доктор/ төгсч байгаа мэргэжилтэнд тавигдах шаардлагыг судалж, судалгааны үр дүнг танилцуулах:*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө №15/*<br>✓ Нягтлан бодогч мэргэжлээр төгсч байгаа мэргэжилтэнд тавигдах шаардлагын талаарх судалгааг ТМЗН-ийн Ёс зүй хяналтын менежментийн хороо хариуцан хийж гүйцэтгэж, судалгааны үр дүнг 2020.04.30-ны 02/51 албан тоотоор хүргүүлэн ажиллаа. | 100% |
| 3.1.6<br>Тус гэрээнд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхдээ татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох. сунгах сургалт, шалгалтыг төлбөртэй зохион байгуулж болох бөгөөд 1 цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг; 1 цагийн шалгалтын төлбөрийн | Өөрчлөлт ороогүй. | |

| | | |
|---|---|---|
| дээд хязгаарыг 8000 /найман мянга/ төгрөг байхаар тооцох | | |
| 3.1.7<br>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагч болон холбогдох байгууллагад нь ирүүлж байх | МУ-ын ТМЗ-ийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэд, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагчид хүргүүлж ажилласан. | |
| 3.1.8<br>Нийгэмлэг өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэний хувьд төлөх татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байх | Өөрчлөлт ороогүй. | |
| 3.1.9<br>Гэрээ гүйцэтгэгч нь гэрээний 3.1.6, 3.1.8-д | Өөрчлөлт ороогүй. | |

| | | |
|---|---|---|
| зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүй байх | | |
| **Гэрээний хэрэгжилтийг шалгах явцад гарсан санал** | | |
| Сангийн яам | | |
| ТМЗН | | |

**ХЯНАСАН:**
САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:
Б.БОЛОРМАА

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАСАН:**
ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:
Г. ХИШИГЗУЛ